



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/105

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар тогтоолын 7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ-ын үндсэн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулахтай холбогдуулан бүтэц, орон тоог өөрчлөн байгуулах санал боловсруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
ахлагч: Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга

Гишүүд: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйл
ажиллагааны мониторингийн хэлтсийн дарга

Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ-ын дарга
Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Замын
хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн
ашиглалт, хамгаалалтын хэлтсийн дарга

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хууль эрх зүйн
мэргэжилтэн

Нарийн бичгийн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
дарга: Инженерийн байгууламжийн хэлтсийн Тээвэр
хөдөлгөөн зохион байгуулалт хариуцсан
мэргэжилтэн

2. Саналыг 2016 оны 09 дүгээр сарын 05-ны дотор Улаанбаатар хотын Ерөнхий менежерт танилцуулахыг Ажлын хэсэг /Б.Энхбаяр/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН УУРГИЙГ ТҮВ ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Энхбаяр* Д.ГАНТӨМӨР

